



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 4/520

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “н” дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 5 дугаар хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан гэрээ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зорилгоор хүний үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн Алтай сумын нутаг Ендөрт-Ус, Тэсэгтэй хэмээх газруудын 5 га газрыг нөхөн сэргээлт хийх ажилд зориулан 10 000 000 төгрөг /арван сая/-ийг зарцуулсугай.

2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/, аймгийн Засаг даргын Тамгын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Батсүх/ нарт үүрэг болгосугай.

3. Дээрхи төсөл арга хэмжээг Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 2.1-д тусгагдсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэх зардал” арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zah A/520-Kh  
09 2738